



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213014 Өмнөговь аймаг, Даланзадгал сум
3-р баг Нутгийн удирдлагын ордон
Утас: 7053-3539, E-mail: umnugovi@audit.gov.mn

2019.03.15 № 143

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой ХК 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Таван толгой ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Таван толгой ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Таван толгой ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.АЛТАНЗАЯА



4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	232,048,502,392.76	116,444,921,013.94
Дансны авлага	23,098,164,008.68	19,538,083,929.47
Татвар, НДШ-ийн авлага	8,570,056.07	208,794,246.29
Бусад авлага	26,172,319.00	106,285,073.06
Бараа материал	1,385,427,310.47	1,561,779,358.32
Урьдчилж төлсөн зардал тооцоо	893,550,859.86	246,983,090.00
Бусад эргэлтийн хөрөнгө	40,890,000.00	42,680,000.00
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,390,760,000.00	1,221,500,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	258,892,036,946.84	139,371,026,711.08
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	11,682,416,292.70	15,998,908,662.01
Биет бус хөрөнгө	1,830,171,499.89	1,790,731,585.20
Урт хугацаат хөрөнгө оруулалт	434,179,457.49	434,179,457.49
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,946,767,250.08	18,223,819,704.70
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	272,838,804,196.92	157,594,846,415.78
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	4,424,853,988.73	12,941,465,521.55
Цалингийн өглөг	90,513,833.50	85,715,187.05
Татварын өр	76,323,497,882.97	37,355,311,366.15
НДШ-ийн өглөг	7,561,011.85	-
Ногдол ашгийн өглөг	529,918,176.78	541,498,118.78
Урьдчилж орсон орлого	24,502,691,006.28	15,779,527,778.10
Богино хугацаат өр төлбөрийн дүн	105,879,035,900.11	66,703,517,971.63
Урт хугацаат өр төлбөр		
Бусад урт хугацаат өр төлбөр	12,511,250.00	453,475,950.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	12,511,250.00	453,475,950.00
Өр төлбөрийн нийт дүн	105,891,547,150.11	67,156,993,921.63
Эздийн өмч		
Төрийн өмч	48,188,698.49	48,188,698.49
Хувийн өмч	46,298,945.60	46,298,945.60
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	511,036,236.35	511,036,236.35
Хуримтлагдсан ашиг	166,341,733,166.37	89,832,328,613.71
Эздийн өмчийн дүн	166,947,257,046.81	90,437,852,494.15
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	272,838,804,196.92	157,594,846,415.78



4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
Борлуулалтын орлого (цэвэр)	427,930,350,000.34	226,360,600,607.87
Борлуулалтын өртөг	233,763,614,591.67	159,581,281,341.18
Нийт ашиг (алдагдал)	194,166,735,408.67	66,779,319,266.69
Хүүгийн орлого	2,792,719,127.03	3,300,789,224.94
Бусад орлого	400,032,395.37	323,154,058.45
Ерөнхий ба удирдлагын зардал	2,193,512,024.93	2,373,436,346.77
Бусад зардал	1,227,959,650.79	2,052,055,712.11
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-4,601,575,235.81	2,702,816,020.73
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	41,564,001.45	0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	189,378,004,020.99	68,680,586,511.93
Орлогын татварын зардал	48,323,359,925.90	15,822,478,633.87
Татварын дараах ашиг (алдагдал)	141,054,644,095.09	52,858,107,878.06
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	141,054,644,095.09	52,858,107,878.06
Орлогын нийт дүн	141,054,644,095.09	52,858,107,878.06



4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	78,403,247,417.24	79,008,771,297.68
Залруулсан үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	78,403,247,417.24	79,008,771,297.68
Зарласан ногдол ашиг	-	-	45,924,054,400.00	45,924,054,400.00
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	141,054,644,095.09	141,054,644,095.09
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	166,341,733,166.37	166,947,257,046.81
Залруулсан үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	166,341,733,166.37	166,947,257,046.81
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	(2,444,380,430.72)	(2,444,380,430.72)
Зарласан ногдол ашиг	-	-	126,923,132,000.00	126,923,132,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	52,858,107,878.06	52,858,107,878.06
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,487,644.09	511,036,236.35	89,832,328,613.71	90,437,852,494.15



4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	0.00
Мөнгөн орлогын дүн (+)	415,119,911,071.16	217,916,979,813.79
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	414,811,216,735.31	217,711,071,324.60
Бусад мөнгөн орлого	308,694,335.85	205,908,489.19
Мөнгөн зарлагын дүн (-)	232,875,880,533.38	213,313,056,465.08
Ажиллагчдад төлсөн	2,658,002,986.62	3,393,636,096.29
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	386,203,388.50	937,000,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	108,383,861,602.02	94,898,966,755.74
Ашиглалтын зардалд төлсөн	18,714,132.00	17,360,204.24
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	243,210,019.44	14,621,688.00
Татварын байгууллагад төлсөн	118,995,835,953.43	111,284,926,035.28
Даатгалын төлбөрт төлсөн	21,476,027.00	108,416,402.20
Бусад мөнгөн зарлага	2,168,576,424.37	2,658,129,283.33
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	182,244,030,537.78	4,603,923,348.71
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	2,792,719,127.03	3,099,505,891.94
Хүлээн авсан хүүний орлого	2,792,719,127.03	3,099,505,891.94
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	3,850,267,966.00	5,428,503,130.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,850,267,966.00	5,428,503,130.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,057,548,838.97)	(2,328,997,238.06)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	43,727,199,255.26	120,598,173,672.20
Төлсөн ногдол ашиг	43,727,199,255.26	120,598,173,672.20
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(43,727,199,255.26)	(120,598,173,672.20)
Валютын ханшийн зөрүү	(4,601,575,235.81)	2,719,666,182.73
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	132,857,707,207.74	(115,603,581,378.82)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	99,190,795,185.02	232,048,502,392.76
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	232,048,502,392.76	116,444,921,013.94